



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/146

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих, Хөдөөгийн сэргэлт чуулганд оролцож аймаг сурталчлах арга хэмжээний зардалд 9,253,890 (есөн сая хоёр зуун тавин гурван мянга найман зуун ер) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 9,253,890 (есөн сая хоёр зуун тавин гурван мянга найман зуун ер) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0244

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар
сарын 04-ны өдрийн 1111/Б дугаар
захирамжийн хавсралт



АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зарцуулалт	Тоо хэмжээ	Нэгж	Нэг бүрийн үнэ (төг)	Нийт үнэ (төг)
1	Чуулганд оролцогчдын бомбер	20	ш	99,000	1,980,000
2	Эх бэлтгэл, стэнд, боршур хэвлэх, сурталчилгаа	1050	ш	1725.7	1,812,000
3	"Нээлттэй Өвөрхангай" баримтат контент бэлтгэх	1	ш		5,000,000
4	Цагаан идээ (сүүн чихэр)	6	кг	18,000	108,000
5	Цайны материал				353,890
	Нийт				9,253,890

-оОо-